

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО ЧИГ ҮҮРГИЙН
ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД: ГАА-2021/15-ШТА-ГА

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын
газар

Дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр
Утас: 70483413

Цахим хаяг:

Tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер Д.Эрдэнэчимэг
Утас: 70484055

Цахим хаяг: Erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Цэцэгмаа

Цахим хаяг: Tsetsegmaab@audit.gov.mn

Аудитор Х.Билэгбаяр

Цахим хаяг: Bilegbayarkh@audit.gov.mn

Аудитор Э.Сүнжидмаа

Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 130


Алтай хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 2 дугаар зүйлийн 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга, Санхүүгийн хяналт, аудитын албанд хүргүүлсүгэй.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Эрдэнэчимэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын
газрын Дарга, Тэргүүлэх аудиторын
20... оны ... дугаар сарын ...-ны
өдрийн ... дугаар тушаалын хавсралт



Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

д/д	Хариуцагч	Товч утга	Дугаар	Зөрчлийн дүн /сая.төгрөг/
1	Аймгийн Засаг даргад	Сахилгын хариуцлага тооцуулах тухай	03/215	
2	Санхүүгийн хяналт аудитын алба	Зөрчил арилгуулах тухай албан шаардлага	01/215	
3	Санхүүгийн хяналт аудитын алба	Зөрчил арилгуулах тухай албан шаардлага	02/215	
	Нийт дүн			

Хураангуй тайлан

Огноо: 2021.10.20

Нэг. Ерөнхий мэдээлэл:

Аудитын код: ГАА-2021/15-ШТА-ГА

Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр: Говь-Алтай аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба

Аудитын нэр: "Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо чиг үүргийн хэрэгжилт"

Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр: Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар

Аудит хийсэн баг, албан тушаалтан: Аудитын 2 дугаар баг

Хоёр. Аудитын үр дүн:

2.1 Аудитын дүн: Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын нэгж буюу Санхүүгийн хяналт, аудитын албаны үндсэн чиг үүрэг, явуулж байгаа үйл ажиллагааг хамруулан шалгалаа.

Аудитын гол дүгнэлт: Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын нэгж буюу санхүүгийн хяналт аудитын алба нь байгуулагдсан цагаасаа хойш санхүүгийн хяналт шалгалт хийсэн боловч сангийн яамнаас гаргасан санхүүгийн хяналт шалгалтын стандартыг үйл ажиллагаандаа мөрдөөгүй, улсын салбарын дотоод аудитын аргачлалыг баримталж ажиллаагүй байна.

2.2 Аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлын нэгтгэл

сая.төг

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Санал
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
A	1	2	3	4	5	6	7	8
1	Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба			3		1		
	Дүн			3		1		

Гурав. Баталгаажуулалт:

Тайлангийн хураангуй бэлтгэсэн: Ахлах аудитор

Аудитор

Аудитор

Анхан шатны чанарын хяналт хийсэн: Аудитын менежер

Хоёр дахь шатны чанарын хяналт хийсэн:

Дарга, тэргүүлэх аудитор

Б.Цэцэгмаа

Х.Билэгбаяр

Э.Сүнжидмаа

Д.Эрдэнэчимэг

Х.Түвшинбаяр

8217144139
ДН 2021/15/3301

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	2
ХҮСНЭГГИЙН ТОВЬЁГ	3
ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁГ	3
ХАВСРАЛТЫН ТОВЬЁГ	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	5
ДЭД ЗОРИЛТ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО	6
ДОТООД АУДИТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДСЭН ҮҮ?	6
Төрийн байгууллагуудын дотоод аудитын эрх зүйн зохицуулалт хангалттай байна уу?	6
Төрийн байгууллагын дотоод аудитын нэгжийн зорилго, эрх мэдэл, үүрэг хариуцлагыг Дотоод аудитын дүрэмд стандартын дагуу бүрэн тусгасан уу?	6
ДОТООД АУДИТЫН НЭГЖ ЧИГ ҮҮРГЭЭ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЦ, ХӨРӨНГӨ, ХҮНИЙ НӨӨЦИЙН БОЛОМЖ ХАНГАГДСАН УУ?	7
Дотоод аудитын нэгж чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэх боломжтой бүтэц, хөрөнгө, хүний нөөц хангалттай байна уу?	7
Дотоод аудитын нэгж чиг үүргээ хөндлөнгийн нөлөөлөлгүй, хараат бусаар гүйцэтгэх боломж бүрдсэн үү?	9
Дотоод аудиторуд Дотоод аудитын дүрэмд заасан шалгуурыг хангаж, бие даасан байдлаар ажиллаж байна уу?	10
ДЭД ЗОРИЛТ 2. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТ ЧИГ ҮҮРГЭЭ ҮР	11
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТ ЧИГ ҮҮРГЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГЭЭ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА УУ?	11
Дотоод аудитын нэгж Дотоод аудитын дүрэм стандартын дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулж байна уу?	11
Дотоод аудитын нэгж чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж байна уу?	12
Дотоод аудитын нэгж үйл ажиллагаагаа хараат бусаар удирдах, хэрэгжүүлэх, хянах, тайлагнах нөхцөл бүрдсэн үү?	12
ДОТООД АУДИТААС ГАРГАСАН ШИЙДВЭРҮҮД ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙНА УУ?	14
Эрх бүхий байгууллагаас дотоод аудитын үр дүнд үнэлгээ хийж, дүгнэлт өгч байна уу? ..	14
Дотоод аудитаар илэрсэн алдаа, зөрчил, өгсөн зөвлөмжийг холбогдох байгууллагууд бүрэн хэрэгжүүлсэн үү?	14
Дотоод аудитын үйл ажиллагаа нь төрийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад хувь нэмэр оруулж байна уу?	15
ДҮГНЭЛТ: АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ДЭРГЭДЭХ ДОТООД АУДИТЫН НЭГЖ БУЮУ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБА НЬ БАЙГУУЛАГДСАН ЦАГААСАА ХОЙШ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН БОЛОВЧ САНГИЙН ЯАМНААС ГАРГАСАН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН СТАНДАРТЫГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА МӨРДӨӨГҮЙ, УЛСЫН САЛБАРЫН ДОТООД АУДИТЫН АРГАЧЛАЛЫГ БАРИМТАЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.	17
ЗӨВЛӨМЖ:	17
АЛБАН ШААРДЛАГА:	17
Холбогдох байгууллагын саналд өгсөн хариу:	18
ХАВСРАЛТУУД:	22

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их Хурал
ГА	Гүйцэтгэлийн аудит
ШТА	Шууд тайлагнах аудит
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ДАМПОУС	Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО, ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Бүтэц орон тоо	09
Хүснэгт 2	Эзлэх хувь	11

ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Тоног төхөөрөмжийн хүрэлцээ	08
Дүрслэл 2	Стандарт хангалт	12
Дүрслэл 3	Ил тод байдал	14
Дүрслэл 4	Актын хэрэгжилт	15
Дүрслэл 5	Харьцуулалт	09

ХАВСРАЛТЫН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Баруун аймгуудын дотоод аудитын нэгжийн орон тоо	20
Хавсралт 2	Баруун аймгуудын дотоод аудитын нэгжийн батлагдсан төсөв цалингийн сангийн гүйцэтгэл	21

Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/27 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт

Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилтийн байдалд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулан Улсын Их хурлын болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо оновчтой эсэх
- Төрийн байгууллагууд дотоод аудитын чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх;

Аудитын хамарсан
хүрээ

Аудитад аймгийн төрийн байгууллагуудын дотоод аудитын зорилго, зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх Төсвийн ерөнхийлөн захирагч болон тэдгээрийн харьяа агентлаг, байгууллагуудын дотоод аудитын үйл ажиллагааны мэдээлэл, тайлан, тоон өгөгдөл болон бусад нотлох баримтад үндэслэн дүн шинжилгээ хийж аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБООУС 3000-3100, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ыг ашиглан төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт, түүний тайлагналын үйл ажиллагаа, хяналт шинжилгээний үнэлгээ зэрэг бодлогын төлөвлөлт, хэрэгжилтийг холбогдох баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулах, асуудал хариуцсан албан тушаалтантай ярилцлага, дүн шинжилгээ хийх, аудитын асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулав.

Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Цэцэгмаа, аудитор Х.Билэгбаяр, Э.Сүнжидмаа нар гүйцэтгэв. Аудитын гүйцэтгэх үе шатны талбарын ажлыг 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр хүртэл гүйцэтгэж аудитын тайланг Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

Хүндрэл бэрхшээл

Аудитыг хийхэд ямар нэгэн хүндрэл бэрхшээл байсангүй.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт (ДАМПОУС)-д “Дотоод аудит”-ыг “Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус бодитой баталгаа өгөх, зөвлөх үйл ажиллагаа, дотоод хяналтын үйл явцыг үнэлэн, хараат бус үнэлгээ өгөх зорилгоор зохих нотолгоонд үндэслэн хийж байгаа шалгалт” гэж тодорхойлсон.

Төсвийн тухай хуульд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангаж, төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна гэж заасан.

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-д төрийн байгууллагуудын дотоод аудитын албаны үйл ажиллагаанд бүх төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн засаг захиргааны дотоод аудитын алба, тэдгээрийн харьяа байгууллагын дотоод аудитын албадын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа хамаарахаар тусгагдсан. Энэхүү дүрэмд дотоод аудитын нэгжийн зорилго, эрх ба үүргийг тодорхойлсон ба Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн дотоод аудитын үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ, зарчим зохион байгуулалт болон дотоод аудиторын эрх үүргийг тодорхойлж дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хөндлөнгийн аудитын байгууллагатай хамтран ажиллах харилцааг зохицуулж байна. Мөн Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”, 2019 оны 268 дугаар тушаалаар “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, 2019 оны 274 дүгээр тушаалаар “Дотоод аудитын чанарын үнэлгээ хийх журам”-ыг тус тус баталсан байна.

Эдгээр дүрэм, журам, стандарт, заавар аргачлалд дотоод аудитын төлөвлөлт, дотоод аудитыг хэрхэн гүйцэтгэх, тайлагнах, зөвлөмжийн хэрэгжилтийг эргэн хянах, дотоод аудитын үйл ажиллагаанд хэрхэн хяналт тавих, төсвийн хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт дүгнэлт өгөх талаар болон дотоод аудитын явцад ашиглах ажлын баримтын загваруудыг гарган үе шат бүрийг тодорхой заасан байна.

Нэгдсэн удирдамжаар хийж байгаа “Төрийн байгууллагын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт” гүйцэтгэлийн аудитын талбарын ажлыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэмжээнд хийхдээ аймгийн Засаг даргын тамгын газрын 2021 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 5/994 дугаартай албан бичгийн хамт ирүүлсэн дотоод аудитын нэгж байгуулах шийдвэр болон үйл ажиллагаа, бүтэц орон тоо, чиг үүргийг баталсан захирамжийг үндэслэл болголоо.

Тус аудитын талбарын ажлыг эхлүүлэхээс өмнө аймгийн хэмжээний төсвийн төвлөрүүлэн захирагч, төсөвт байгууллага дотоод аудитын нэгжтэй эсэх, эсвэл хариуцсан албан тушаалтантай эсэх, тухайн албан тушаалтны мэдлэг ур чадвар болон төсвөөс тус ажлыг хариуцсаны төлөө авсан цалин урамшууллын нэгдсэн судалгаа гаргаж анализ хийсэн. Мөн аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс, Санхүүгийн хяналт аудитын албаны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг давтан тооцох, удирдлагуудтай ярилцлага хийх бусад мэдээлэл цуглуулах арга зүйг ашиглан тухайн нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, хийж хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийг гаргаж дүн шинжилгээ хийв.

Дээрх мэдээллийг нэгтгэн боловсруулж энэхүү аудитын асуудлын шинжилгээ арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж түүнд үндэслэн аудитын дүн дүгнэлт гаргаснаа энэхүү тайлангаар хураангуйллаа.

ДЭД ЗОРИЛТ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО ОНОВЧТОЙ БАЙНА УУ?

ДОТООД АУДИТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДСЭН ҮҮ?

Төрийн байгууллагуудын дотоод аудитын эрх зүйн зохицуулалт хангалттай байна уу?

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын нэгж буюу аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны үйл ажиллагаа нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”, 2019 оны 268 дугаар тушаалаар батлагдсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, 2019 оны 274 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын чанарын үнэлгээ хийх журам”, 2019 оны 29 дугаар тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм” болон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны А/545 дугаартай захирамжаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ээр зохицуулагдаж байна.

Улсын салбарын дотоод аудитын тогтолцоог бүрдүүлэхээр гаргасан дээрх дүрэм, стандарт, аргачлал нь өнөө үед улсын салбарт дотоод аудитын тогтолцоог бий болгох, удирдлага үр дүнтэй хяналт хэрэгжүүлэн төсвийн үр ашигт байдлыг нэмэгдүүлэх сайн засаглал бий болгох жишиг тогтооход үнэтэй хувь нэмэр оруулж байгаа боловч шинэчлэл сайжруулалт хийгдэх нэгэнт гарсан стандарт, аргачлалыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх нутагшуулах тал дээр идэвх зүтгэл шаардлагатай юм. Дотоод аудит хэрэгжүүлэх зорилгоор батлагдсан стандарт аргачлалыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хууль, Дотоод аудитын дүрэмд зохих өөрчлөлт оруулах нь зүйтэй юм.

Учир нь дотоод аудит нь харьцангуй өргөн ойлголт билээ. Гэтэл төсвийн тухай хуулийн 69.3¹-д дотоод аудитад ... санхүүгийн үйл ажиллагааг хамаарна гэж заасан нь дотоод аудитын цар хүрээг хумьж байна.

Одоо мөрдөж байгаа “Дотоод аудитын дүрэм” нь 2015 онд батлагдсан ба цаг үеийн шаардлагаар шинэ батлагдсан стандарт аргачлалд нийцүүлэн шинэчлэлт хийх шаардлага тулгарсан байна.

Дүгнэлт: Дотоод аудитын эрх зүйн зохицуулалт тодорхой төвшинд бүрдсэн боловч шинэчлэлт сайжруулалт хийх шаардлага тулгарсан байна.

Төрийн байгууллагын дотоод аудитын нэгжийн зорилго, эрх мэдэл, үүрэг хариуцлагыг Дотоод аудитын дүрэмд стандартын дагуу бүрэн тусгасан уу?

Дотоод аудитын дүрэмд дотоод аудитын нэгжийн зорилго, эрх мэдэл, үүрэг хариуцлага бүрэн туссан боловч доор зүйлсийг эргэн харж сайжруулах шаардлагатай байдал ажиглагдлаа.

1. “Дотоод аудитын дүрэм”-ийн 8.5²-д чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ гэж заасан нь дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын заалтыг чангаруулсан заалт байна. Уг стандартад хөндлөнгийн үнэлгээг 5 жил тутам хийлгэнэ гэж заасан.
2. “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.4³-д дотоод аудиторт тавигдах ерөнхий заалт тусгагдсан гэтэл Төрийн албаны зөвлөлөөс баталсан дотоод аудиторын ажлын байрны тодорхойлолтод эрх зүйч мэргэжил ороогүй байна. Мөн дотоод аудиторын цалингийн зэрэглэл Засгийн газрын 2020 оны 284 дүгээр тогтоолоор өөрчлөгдсөн байхад батлагдсан ажлын байрны тодорхойлолтод одоогийн байдлаар өөрчлөлт

¹ Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна.

² Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ.

³ Дотоод аудитор нь санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг, эрх зүйн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй, тухайн салбарт мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний зөвшөөрлөөр албан ёсоор зохион байгуулсан сургалтад хамрагдсан байна.

ороогүй байна. Жич: аймгийн санхүүгийн хяналт, аудитын албанаас дээрх өөрчлөлтийг тусгаж өөрчлөлт оруулж өгөхийг алба бичгээр хүргүүлсэн байна.

3. Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-д “дотоод аудитын жилийн төлөвлөгөөнд тусгасан аудитын удирдамжийг тухайн төсвийн ерөнхийлөн захирагч батална” гэж заасан ба сангийн сайдын баталсан “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”-д “санхүүгийн хяналт шалгалтын байгууллагын дарга...шалгалтыг төлөвлөх явцад зөвлөгөө өгөх, шалгалтын удирдамжийг батлах...” гэсэн заалт тайлбар багтсан нь 2 өөр утгыг илэрхийлж байна.
4. Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 6.1.5⁴-д тусгасан дотоод аудиторын эрхийг дотоод аудиторууд эдэлж чадахгүй байна. Учир нь банкны тухай хуульд энэ асуудлыг тусгаагүй байна.

Эрх зүйн байдал тодорхойлогдсон аймгийн дотоод аудитын хороо байгуулагдсан боловч үйл ажиллагааг тогтмол байлгах, идэвхтэй үйл ажиллагаа явуулах тал дээр санаачилга дутмаг байна.

Дүгнэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс эрх зүйн байдал тодорхойлогдсон дотоод аудитын хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Илэрсэн асуудал

Аймгийн санхүүгийн хяналт, аудитын алба нь үйл ажиллагаандаа Сангийн яамнаас баталсан “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”, “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ыг мөрдөж ажиллаагүй

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэд “Аудитын хороо” байгуулагдсан боловч үйл ажиллагаа явуулаагүй байна.

ДҮГНЭЛТ: ДОТООД АУДИТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН ТОДОРХОЙ ТӨВШИНД БҮРДСЭН БОЛОВЧ ТҮҮНИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНД НЭВТРҮҮЛЭХ ТАЛ ДЭЭР ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ БОЛОН ТҮҮНИЙ ДЭРГЭДЭХ ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ОРОЛЦОО ДУТМАГ БАЙНА.

ДОТООД АУДИТЫН НЭГЖ ЧИГ ҮҮРГЭЭ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЦ, ХӨРӨНГӨ, ХҮНИЙ НӨӨЦИЙН БОЛОМЖ ХАНГАГДСАН УУ?

Дотоод аудитын нэгж чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэх боломжтой бүтэц, хөрөнгө, хүний нөөц хангалттай байна уу?

ХҮНИЙ НӨӨЦ: Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгжид ажиллах дотоод аудитор нь Засгийн газрын 2015 оны 483 дугаартай “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.4⁵, Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 340 дугаартай тогтоолоор батлагдсан ажлын байрны тодорхойлолтын тусгай шаардлага, мэргэжил, мэргэшил⁶ хэсэг, аймгийн Засаг даргын 2014 оны А/545 дугаартай захирамжаар батлагдсан “Санхүүгийн хяналт шалгалтын болон дотоод аудитын дүрэм”-ийн 4.4⁷-т заасан мэргэжил эзэмшсэн тухайн салбартаа мэргэшсэн албан хаагч байхаар журамлагдсан байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын нэгж буюу Санхүүгийн хяналт аудитын алба нь 2014 онд үүсгэн байгуулагдсан байна. Тус албаны

⁴ санхүүгийн тайлан, баримтыг баталгаажуулахтай холбоотой б

баримт бичигтэй танилцах хүсэлт холбогдох банк, санхүүгийн байгууллагад тавих

⁵ Дотоод аудитор нь санхүү нягтлан бодох бүртгэл эдийн засаг эрх зүйн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй тухайн салбарт мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний зөвшөөрлөөр албан ёсоор зохион байгуулсан сургалтад хамрагдсан байна.

⁶ Ажлын байрны тодорхойлолтын тусгай шаардлага Боловсрол: Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх Мэргэжил: Нягтлан бодох бүртгэл, Эдийн засаг санхүү банк, Мэргэшил: Мэргэшсэн нягтлан бодогч байх

⁷ Дараах шаардлагын хангасан хүнийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санхүүгийн хяналт, аудитын албаны улсын байцаагч/ахлах/ дотоод аудитораар томило. 4.4.1 Санхүү нягтлан бодох бүртгэл эдийн засгийн мэргэжлийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх, 4.4.2 Үнэнч шударга байх, 4.4.3 Тухайн албан тушаалд харшлахгүй талаарх Авлигатай тэмцэх газар, цагдаагийн байгууллагын тодорхойлолт

бүтэц орон тоо аймгийн Засаг дарга буюу Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны Б/98 дугаартай захирамжаар батлагдсан байна. (Хүснэгт№1)

Хүснэгт №1 Бүтэц орон тоо

№	Батлагдсан орон тоо албан тушаал		Ажилласан байдал		
	Албан тушаал	Тоо	2019	2020	2021
1	Албаны дарга	1	1	1	1
2	Дотоод аудитор	4	4	4-5	5
3	Нягтлан бодогч, архив бичиг хэргийн ажилтан	1	1	1-0	х
	Дүн	6	6	6	6

Хүснэгтэд Санхүүгийн хяналт аудитын албаны батлагдсан бүтэц болон гүйцэтгэлээр ажилласан бүтцийг харьцуулж харууллаа. Албаны бүтэц орон тоо баталсан шийдвэрт өөрчлөлт ороогүй байхад 2020 оны 12 дугаар сараас албаны дарга 1, дотоод аудитор 5 гэсэн бүтцээр ажилласан байна.


Эх сурвалж: Аймгийн Засаг даргын Б/98

ХӨРӨНГИЙН НӨӨЦ: Санхүүгийн хяналт, аудитын албаны хөрөнгийн үлдэгдлийг тулган баталгаажуулахад 35 нэр төрлийн 61 ширхэг 19.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, албаны хэвийн үйл ажиллагааг хангах зориулалттай 40 нэр төрлийн 143 ширхэг 1.6 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байлаа. Тус алба үйл ажиллагаа явуулах өөрийн байргүй ба аймгийн Засаг даргын тамгын газрын II байранд 2 өрөөнд байрлаж үйл ажиллагаагаа явуулж байна.

Аудитын хугацаанд тус албаны үндсэн хөрөнгө бараа материалын үлдэгдэлд тооллого хийхэд хөрөнгө, материалын үлдэгдэл зөрүүгүй тохирсон. Дотоод аудиторуудаас авсан ярилцлагаар албан хэрэгцээнд ашиглаж байгаа тоног төхөөрөмж хангалттай байдгаа илэрхийлсэн байна.

Албаны даргын зүгээс албан хэрэгцээнд автомашин байх зайлшгүй шаардлагатай байдаг талаар ярилцлагын үеэр онцгойлон тодруулж байсан. Аудитаар автомашины хэрэгцээ шаардлага бодитой эсэхийг судлахад “Дотоод аудитын дүрэм”-ийн 6.1.4⁸ дэх заалтаар энэ асуудал зохицуулагдаж байна. Албан ажлаар сумд ажиллахад аймгийн ЗДТГ-аас автомашинаар хангаж байгаа тул үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх үндсэн хөрөнгөд бүртгэлтэй автомашин заавал байх шаардлагагүй гэж үзлээ. Шаардлагатай үедээ автомашин аймгийн ЗДТГ-аас авах нь хуримтлагдсан элэгдлийн зардал болон тухайн автомашинтай холбоотой засвар арчлалт, цалингийн зардлыг хэмнэж байна.

Дүрслэл №1 Тоног төхөөрөмжийн хүрэлцээ



Тус албаны албан хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжид дүн шинжилгээ хийхэд 4 дотоод аудитор дунд 1 дуу хураагууртай, компьютерын 33 хувь нь 2020 онд шинээр авсан 17 хувь нь 2015 онд авсан, 17 хувь нь 2016 онд авсан 33 хувь нь 2017 онд авсан, принтерийн насжилт нь мөн 2015-2020 онд ашиглалтад орсон буюу нөөц бололцоондоо тохируулан тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг тасралтгүй

хийдэг болох нь харагдаж байна. Тавилга хэрэгслийн тухайд бүрэн хангагджээ.

САНХҮҮГИЙН НӨӨЦ: Санхүүгийн хяналт, аудитын албаны хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс орон нутгийн төсвөөс жилд 119.1-126.8 сая төгрөгийн төсөв батлагдан зарцуулагдаж байна. Батлагдсан төсвийн судалгааг гаргахад тус албаны төсөв жил бүр өссөн үзүүлэлт гарч байна.

⁸ шаардлагатай бол тухайн байгууллагын байр, тоног төхөөрөмж, хэрэгслийг ашиглах

ХАРЬЦУУЛАЛТ: Баруун аймгуудын харьцуулсан судалгаа хийхэд хүн амын тухайд манай аймаг 58,220 хүн амд 179 төсөвт байгууллага, 15 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд төрийн үйлчилгээг үзүүлж байна. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын нэгжийн дээр дурдсан нөөцийг баруун аймгуудтай харьцуулан судлахад батлагдсан орон тоо 1-ээс 5-аар цөөн гүйцэтгэлээр ажилласан орон тоо Баян-Өлгий аймгаас 1-ээр цөөн, Ховд аймгаас 5-аар цөөн, Завхан аймгаас 4-өөр цөөн байна. Орон тооны зөрүүнээс шалтгаалан батлагдан зарцуулж буй төсөв мөн бага байна. /Хавсралт-1/



Эх сурвалж: www.1212.mn сайт

Дүгнэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний асуудалд одоогийн бүтэц, төсвөөр чиг үүргээ хэрэгжүүлэх боломжтой байна.

Дотоод аудитын нэгж чиг үүргээ хөндлөнгийн нөлөөлөлгүй, хараат бусаар гүйцэтгэх боломж бүрдсэн үү?

Дотоод аудитын нэгжийн хараат бус байдлыг ДАМПОУС-1100 хараат бус байдал ба бодитой хандлага, ДАМПОУС-1110 зохион байгуулалтын хараат бус байдал, ДАМПОУС-1111 Зөвлөлтэй шууд харилцах, ДАМПОУС-1112 аудитын гүйцэтгэх удирдлагын дотоод аудитаас бусад хүлээх үүрэг стандартыг хангах мөн Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.2⁹, аймгийн Засаг даргын 2014 оны А/545 дугаартай захирамжаар батлагдсан “Санхүүгийн хяналт шалгалтын болон дотоод аудитын дүрэм”-ийн 1.3¹⁰, 4.2¹¹ дэх заалтад зааснаар тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагчийн шууд удирдлагад ажиллаж 7.2¹² дахь заалтад зааснаар тухайн жилийн төлөвлөгөөнд туссан аудитын удирдамжийг төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулж, 7.6¹³ дахь заалтад зааснаар, шалгалтын дүн нэгжийн төлөвлөгөөний биелэлт, өгсөн шийдвэрийн хэрэгжилтийн явц, аудитад хамрагдсан нэгжийн үйл ажиллагаанд анхаарах асуудал холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох санал зэргийг танилцуулахаар байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь тогтолцооны хувьд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн шууд удирдлагад үйл ажиллагаагаа явуулж байгаа боловч тухайн жилд хийгдэх аудитын төлөвлөгөө, удирдамж, хяналт шалгалт хийсэн нэгжийн танилцуулгыг төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулаагүй байна.

⁹ Дотоод аудитын нэгж нь төсвийн ерөнхийлөн захирагчид ажлаа хариуцан тайлагнана.

¹⁰ Санхүүгийн хяналт, аудитын алба нь санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бодлого зорилтод уялдуулан Засаг даргын шууд удирдлага доор үйл ажиллагаагаа явуулна.

¹¹ Санхүүгийн хяналт аудитын алба нь төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяанд ажиллана. Санхүүгийн хяналт аудитын албаны дарга нь зөвхөн төсвийн ерөнхийлөн захирагчид ажлаа тайлагнана.

¹² Дотоод аудитын жилийн төлөвлөгөөнд тусгасан аудитын удирдамжийг тухайн төсвийн ерөнхийлөн захирагч батална.

¹³ Дотоод аудитын нэгжийн дарга дараах асуудлыг Дотоод аудитын хороо, төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулж тайлагнана:

7.6.1. гүйцэтгэсэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын дүн;

7.6.2. нэгжийн жилийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн явц;

7.6.3. холбогдох акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн явц;

7.6.4. хөндлөнгийн байгууллагаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн явц;

7.6.5. аудитад хамрагдсан байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд анхаарах асуудал, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох санал.

Дүгнэлт: Хараат бус байдал тогтолцооны хувьд бүрдсэн боловч төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын нэгж, төсвийн ерөнхийлөн захирагчийн хоорондын харилцаа энэ хугацаанд бүрэн төлөвшөөгүй байна.

Дотоод аудиторуд Дотоод аудитын дүрэмд заасан шалгуурыг хангаж, бие даасан байдлаар ажиллаж байна уу?

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгжид ажиллах дотоод аудитор нь Төсвийн тухай хуулийн 69.4¹⁴, Засгийн газрын 2015 оны 483 дугаартай “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.4¹⁵, Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 340 дугаартай тогтоолоор батлагдсан ажлын байрны тодорхойлолтын тусгай шаардлага, мэргэжил, мэргэшил¹⁶ хэсэг, аймгийн Засаг даргын 2014 оны А/545 дугаартай захирамжаар батлагдсан “Санхүүгийн хяналт шалгалтын болон дотоод аудитын дүрэм”-ийн 4.4¹⁷-т заасан мэргэжил эзэмшсэн тухайн салбартаа мэргэшсэн албан хаагч байхыг дүрэмд тусгасан байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны бүтцэд байгаа дотоод аудиторуд нь санхүүч, нягтлан бодогч мэргэжилтэй улсын (ахлах) байцаагчид байгаа нь санхүүгийн хяналт шалгалт хийхэд ДАМПОУС-2130¹⁸ буюу дотоод хяналтыг хэрэгжүүлэхэд давуу талтай боловч ДАМПОУС-2110¹⁹ буюу Засаглал, ДАМПОУС-2120²⁰ буюу Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд учир дутагдалтай байна.

Санхүүгийн хяналт аудитын албаны дотоод аудиторудад дээрх стандартыг хангах зөвлөмж өгөх Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-д тусгагдсан эрх зүйн чиглэлээр мэргэжил эзэмшсэн ажилтан ажиллавал давуу тал болохоор байна.

Дотоод аудиторын ажлын ачаалал: Санхүүгийн хяналт аудитын албаны дотоод аудиторын ачааллыг сүүлийн 3 жилээр гаргахад 1 дотоод аудитор жилд дунджаар 18-28 нэгжийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийсэн байна. (Хүснэгт №2)

Хүснэгт №2

Эзлэх хувь

№	Ажиллагсдын нэрс	Албан тушаал	Хийгдсэн хяналт шалгалтад эзлэх хувь		
			2019 он	2020 он	2021.III
1	Д.Ганзориг	Албаны дарга	2%	2%	1%
2	Ц.Баттөр	Дотоод аудитор	26%	23%	26%
3	Б.Бүрэндэлгэр	Дотоод аудитор	26%	22%	23%
4	Б.Дэлгэрбаяр	Дотоод аудитор	26%	28%	17%
5	Ч.Дулмаа	Дотоод аудитор	19%	25%	8%
6	А.Мөнхтөр	Ня-бо АБХА / Дотоод аудитор	1%	-	25%
	Дүн		100%	100%	100%

Тус алба нь 2019 онд 95 нэгжид, 2020 онд 68 нэгжид, 2021 оны III улирлын байдлаар 33 нэгжид санхүүгийн хяналт шалгалт хийснийг хяналт шалгалтад оролцсон ажиллагсадтай тоон утгаар хувьчилж гаргахад хүснэгт №2-т туссан дүн гарч байна.

Эх сурвалж: Дээрх онуудын баримт материал

¹⁴ Дотоод аудитор нь санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрхтэй байна.

¹⁵ Дотоод аудитор нь санхүү нягтлан бодох бүртгэл эдийн засаг эрх зүйн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй тухайн салбарт мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний зөвшөөрлөөр албан ёсоор зохион байгуулсан сургалтад хамрагдсан байна.

¹⁶ Ажлын байрны тодорхойлолтын тусгай шаардлага Боловсрол: Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх Мэргэжил: Нягтлан бодох бүртгэл, Эдийн засаг санхүү банк, Мэргэшил: Мэргэшсэн нягтлан бодогч байх

¹⁷ Дараах шаардлагын хангасан хүнийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санхүүгийн хяналт, аудитын албаны улсын байцаагч/ахлах/ дотоод аудитораар томилно. 4.4.1 Санхүү нягтлан бодох бүртгэл эдийн засгийн мэргэжлийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх, 4.4.2 Үнэнч шударга байх, 4.4.3 Тухайн албан тушаалд харшлахгүй талаарх Авлигатай тэмцэх газар, цагдаагийн байгууллагын тодорхойлолт

¹⁸ Дотоод аудитын нэгж дотоод хяналтын үр нөлөөтэй ба үр ашигт байдалд үнэлгээ хийх, тэдгээрийн байнгын сайжруулалтад дэмжлэг үзүүлэх замаар үр нөлөөтэй дотоод хяналтын системийг бий болгоход байгууллагад туслалцаа үзүүлэх ёстой.

¹⁹ Дотоод аудитын нэгж байгууллагын засаглалын үйл явцыг үнэлэн, сайжруулах зөвлөмжийг өгөх ёстой.

²⁰ Дотоод аудитын нэгж байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл явцыг үр нөлөөтэй байдлыг үнэлэн, сайжруулахад хувь нэмэр оруулах ёстой.

Дүгнэлт: Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгжийн дотоод аудиторын албан тушаалд ажиллаж байгаа дотоод аудиторууд нь “Дотоод аудитын дүрэм”-д заасан шалгуурыг хангаж байна.

ДУГНЭЛТ: ДОТООД АУДИТЫН НЭГЖ ЧИГ ҮҮРГЭЭ ҮР ДҮНТЭЙ ГҮЙЦЭТГЭХ БОЛОМЖТОЙ БҮТЭЦ, ХӨРӨНГӨ, ХҮНИЙ НӨӨЦ БҮРДСЭН БАЙНА.

ДЭД ЗОРИЛТ 2. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТ ЧИГ ҮҮРГЭЭ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА УУ?

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТ ЧИГ ҮҮРГЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГЭЭ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА УУ?

Дотоод аудитын нэгж Дотоод аудитын дүрэм стандартын дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулж байна уу?

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2019-2020 онд хийж гүйцэтгэсэн 163 нэгжид хийсэн 72 хяналт шалгалтын удирдамж танилцуулга өгсөн акт, албан шаардлага, танилцуулга, дурдсан асуудлын нотлох баримт хэрэгжилт гэх мэт аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны үндсэн үйл ажиллагааны баримт материалыг үндэслэл болгосон.

Батлагдсан аргачлал, стандарт хангалтын байдлыг гаргахад сангийн сайдын 2019 оны 268 дугаартай тушаалаар батлагдсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ыг үйл ажиллагаандаа мөрдөөгүй байна. Харин сангийн сайдын 2016 оны 107 дугаартай тушаалаар батлагдсан “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”-ын 6 агуулгаас 10 заалтыг түүвэрлэн авч нарийвчлан үзэхэд дараах байдалтай байна.

Дүрслэл №2 Стандарт хангалт



- Мэргэжлийн ур чадвар арга барил хэсэгт багтсан удирдах хянах²¹ асуудлыг тулган баталгаажуулахад хийгдсэн хяналт шалгалтын 13 хувийг албаны дарга хянан удирдсан байна.

- Ажлын цар хүрээ хэсэгт багтсан шалгагдаж байгаа байгууллагын дотоод хяналтын системийг үнэлж дүгнэх, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал, эд хөрөнгө, нөөц бололцоог үр өгөөж, үр

дүнтэйгээр ашигласан байдлыг хангалттай хэмжээнд тодорхойлжээ.

- Санхүүгийн хяналт шалгалтын гүйцэтгэл хэсэгт шалгалтыг төлөвлөх шалгагдаж байгаа байгууллагын талаар үндсэн мэдээлэл олж авсан байдлыг үнэлэхэд хийсэн хяналт шалгалтын дийлэнх хувьд зөвхөн өмнө хийгдсэн хяналт шалгалтын материал, тухайн байгууллагын орон тоо, төсвийн талаарх мэдээллийг олж цуглуулсан байна. Стандартад тусгасан үндсэн мэдээллийг бүрэн цуглуулсан 4 хяналт шалгалт хийгдсэн байна. Үндсэн мэдээлэл олж цуглуулахдаа гадны эх үүсвэр ашиглах, шалгалтын үйл ажиллагаатай шууд холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага явуулах зэрэг нэмэлт эх үүсвэр огт хэрэглээгүй байна.
- Баримт мэдээллийг үнэлж дүгнэх хэсэгт шалгагдагч байгууллагаас баримт материал хүлээлцсэн байдлыг тулган баталгаажуулахад хамрагдсан хяналт шалгалтын материалын 66 хувь буюу 108 нэгжийн баримт материалыг хүлээлцээгүй байна.
- Удирдамжид заагдсан нийт 553 асуудлаас 495 нь буюу 90 хувь нь танилцуулгад дурдагдсан үлдэх 10 хувь буюу 58 нь үзэгдсэн эсэх нь тодорхойгүй байна.

²¹ Санхүүгийн шалгалтын байгууллагын дарга санхүүгийн шалгалтын явцыг удирдаж хяналт тавина.

- Ажлын баримт материал нь шалгалтын үр дүн илрүүлсэн зүйл зөвлөмж зэргийг илэрхийлж баталж чадахуйц бодитой холбогдолтой хангалттай байж түүнийг бүрэн баримтжуулсан эсэхийг тулган баталгаажуулахад нийт хяналт шалгалтын 24 хувь буюу 40 нэгжийн ажлын баримт материал шалгалтын үр дүнд илэрхийлсэн зүйл зөвлөмжийг илэрхийлж чадахуйц байна.
- Хяналт шалгалтын ажлын нотолгоо хэсэгт танилцуулгад тусгагдсан асуудал, акт, албан шаардлага өгсөн зөрчилд нотлох баримт цуглуулсан байдлыг үнэлсэн. Хяналт шалгалтад хамрагдсан 65 нэгжийн танилцуулгад тусгасан асуудал нотлох баримтаар дэмжигдсэн. Хяналт шалгалтад хамрагдсан 120 нэгжийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчилд акт тогтоосноос 75 нэгжийн илэрсэн зөрчил нотлох баримтаар дэмжигдээгүй, 110 нэгжийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчилд албан шаардлага өгснөөс 62 нэгжийн илэрсэн зөрчил нотлох баримтаар дэмжигдээгүй байна.
- Хараат бус байдал хэсэгт дотоод аудиторын гаргасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл бөглөсөн байдлыг тулган баталгаажуулсан шалгалтад хамрагдсан нэгжийн 10 хувь буюу 16 нэгжид шалгалт хийхдээ хараат бус байдлаа илэрхийлэх мэдэгдэл бөглөөгүй байна.
- Стандартад заагдсан хоногийн дагуу эдгээр хяналт шалгалтыг хийхэд 1271 хоног зарцуулах байсан бол гүйцэтгэлээр 644 хоногт хийсэн нь нийт зарцуулбал зохих хугацааны 51 хувьтай тэнцэж байна.

Дүгнэлт: “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ыг огт мөрдөөгүй, “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”-ын мөрдөлт хангалтгүй байна.

Дотоод аудитын нэгж чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж байна уу?

Санхүүгийн хяналт, аудитын албыг чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж байгаа байдлыг төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-д тусгасан чиг үүргийн хүрээнд 2019-2020 онд 163 нэгжийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын хүрээнд гаргахад “Дотоод аудитын дүрэм” -ийн 5.1.4²², 5.1.5²³, 5.2.1²⁴-т заасан чиг үүргийг хяналт шалгалтын удирдамжид хамгийн бага буюу 1-3 нэгжийн удирдамжид тусгасан байна.

Санхүүгийн хяналт аудитын алба нь төсвийн тухай хуульд заасан санхүүгийн хяналт шалгалт хийх чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан боловч дотоод аудитын нэгжийн тухайд гүйцэтгэх засаглалын үйл явцыг үнэлэн сайжруулах, эрсдэлийн удирдлагын үйл явцын үр нөлөөт байдлыг үнэлэн сайжруулах чиглэлд хангалттай хэмжээнд ажиллаагүй байна.

Дүгнэлт: Дотоод аудитын нэгж зөвхөн санхүүгийн хяналт шалгалт хийх чиг үүргээ хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын нэгж үйл ажиллагаагаа хараат бусаар удирдах, хэрэгжүүлэх, хянах, тайлагнах нөхцөл бүрдсэн үү?

Санхүүгийн хяналт аудитын алба үйл ажиллагаагаа хараат бусаар удирдах, хэрэгжүүлэх, хянах эрх зүйн нөхцөл бүрдсэн байна. Тус албанд хуучнаар мэргэжлийн хяналтын газрын бүтцэд ажилладаг байсан санхүүгийн улсын байцаагчид багтсан ба хүний нөөц харьцангуй тогтвортой буюу 2016 оноос хойш ажиллаж байгаа бүрэлдэхүүнд ямар нэгэн өөрчлөлт ороогүй байна.

Аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны удирдлага нь үйл ажиллагаа явуулахдаа дагаж мөрдвөл зохих дүрэм, аргачлал, стандартыг мөрдөөгүй албаны үйл ажиллагаа хяналтгүй урсгалаараа явагдаж байна.

Дүгнэлт: Дотоод аудитын нэгж үйл ажиллагаагаа хараат бусаар удирдах, хэрэгжүүлэх, хянах тайлагнах нөхцөл бүрдсэн байна.

²² санхүү, төсөв, төрийн сангийн үйл ажиллагааны үнэн зөв, найдвартай байдал

²³ салбарын эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр ашигтай байдал

²⁴ төсөв, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон тэдгээрийг үндэслэн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, заавар, стандарт, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих

Дотоод аудитын үр дүнг олон нийтэд ил тод тайлагнаж мэдээллийн нэгдсэн санг бий болгосон уу?

Аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь “Говь-Алтай аймгийн санхүүгийн хяналт аудитын алба” гэсэн нэртэй вэб хуудас хөтөлдөг боловч 2020 оны 8 дугаар сараас хойш мэдээлэл оруулаагүй байна. Хийсэн хяналт шалгалтын үр дүнг олон нийтэд ил тод тайлагнадаг эсэхэд төсвийн байгууллагын нягтлан бодогчдыг хамруулсан санал асуулга авахад нийт хариултын 12.2 хувь нь үгүй, 46.3 хувь нь зөвхөн шалгагдагч байгууллагадаа танилцуулдаг, 41.5 хувь нь тийм гэсэн хариулт ирүүлсэн байна.

Дүрслэл №3 Ил тод байдал



Эх сурвалж:

Санал асуулгын дүнгээс

Түүвэрт хамрагдсан 163 нэгжийн хяналт шалгалтын материалын 73 хувь буюу 120 нэгжийн 56 танилцуулгыг дээрх вэб хуудаст байршуулсан байна.

Аудитаар тус албанд бий болсон мэдээллийн санг үзэх төлөвлөгөөтэй байсан боловч бий болсон мэдээллийн сан байсангүй.

Дүгнэлт: Аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь өөрийн хөтөлдөг вэб хуудаст 2020 оны 8 дугаар сараас хойш мэдээлэл оруулаагүй, тус албанд хяналт шалгалттай холбоотой ямар нэгэн мэдээллийн нэгдсэн сан бий болоогүй байна.

Илрүүлсэн асуудал

- Хийгдсэн хяналт шалгалтын 87 хувийг албаны дарга хянан удирдаагүй
- Стандартад тусгасан үндсэн мэдээллийг бүрэн цуглуулалгүйгээр 68 нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна.
- Аудитад хамрагдсан хяналт шалгалтын материалын 66 хувь буюу 108 нэгжийн баримт материалыг хүлээлцээгүй
- Хяналт шалгалтын удирдамжид заагдсан нийт 553 асуудлын 10 хувь буюу 58 нь хяналт шалгалтаар үзэгдсэн эсэх нь тодорхойгүй
- Ажлын баримт материал нь шалгалтын үр дүн илрүүлсэн зүйл зөвлөмж зэргийг илэрхийлж баталж чадахуйц бодитой холбогдолтой хангалттай байж түүнийг бүрэн баримтжуулсан эсэхийг тулган баталгаажуулахад нийт хяналт шалгалтын 76 хувь буюу 123 нэгжийн ажлын баримт материал шалгалтын үр дүнд илэрхийлсэн зүйл зөвлөмжийг илэрхийлж чадахгүй байна.
- Хяналт шалгалтад хамрагдсан 98 нэгжийн танилцуулгад тусгасан асуудал нотлох баримтаар дэмжигдэхгүй байна.
- Хяналт шалгалтад хамрагдсан 120 нэгжийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчилд акт тогтоосноос 75 нэгжийн илэрсэн зөрчил нотлох баримтаар дэмжигдээгүй, 110 нэгжийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчилд албан шаардлага өгснөөс 62 нэгжийн илэрсэн зөрчил нотлох баримтаар дэмжигдээгүй байна.
- Дотоод аудиторуудын ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл бөглөсөн байдлыг тулган баталгаажуулсан шалгалтад хамрагдсан нэгжийн 10 хувь буюу 16 нэгжид шалгалт хийхдээ хараат бус байдлаа илэрхийлэх мэдэгдэл бөглөөгүй байна.
- Түүвэрт хамрагдсан 163 нэгжийн хяналт шалгалтын материалын 27 хувь буюу 43 нэгжийн 16 танилцуулгыг албаны вэб хуудаст байршуулаагүй байна.

ДҮГНЭЛТ: САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБА НЬ ЧИГ ҮҮРГЭЭР ХҮЛЭЭСЭН ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ҮҮРГЭЭ ХАНГАЛТТАЙ ТӨВШИНД ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

ДОТООД АУДИТААС ГАРГАСАН ШИЙДВЭРҮҮД ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙНА УУ?

Эрх бүхий байгууллагаас дотоод аудитын үр дүнд үнэлгээ хийж, дүгнэлт өгч байна уу?

Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартаар дотоод аудитын нэгжид 5 жил тутамд хөндлөнгийн үнэлгээ хийгдэхээр Засгийн газраас баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 8.5²⁵-д чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ гэж заасан байна.

Санхүүгийн хяналт аудитын алба нь 2014 онд анх байгуулагдсан ба энэ хугацаанд тус байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ хийж дүгнэлт өгөгдөж байгаагүй байна.

Дүгнэлт: Эрх бүхий байгууллагаас дотоод аудитын нэгжийн дотоод аудитын үр дүнд үнэлгээ хийж дүгнэлт өгөөгүй байна.

Дотоод аудитаар илэрсэн алдаа, зөрчил, өгсөн зөвлөмжийг холбогдох байгууллагууд бүрэн хэрэгжүүлсэн үү?

Санхүүгийн хяналт аудитын албаны хийсэн хяналт шалгалтаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн нэгтгэлийг Сангийн яам нэгдсэн байдлаар авч цахим мэдээллийн сан үүсгэсэн ба үүнээс өөр албажсан мэдээлэл байсангүй.

Санхүүгийн хяналт, шалгалтаар илэрсэн зөрчилд өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг тулган баталгаажууллаа.

Дүрслэл №4 Актын хэрэгжилт



Тус албаны 2019-2020 онд 73 нэгжид илэрсэн зөрчилд тогтоосон 46.9 сая төгрөгийн актын 93 хувь буюу 43.8 сая төгрөг хангагдсан, 7 хувь буюу 3.2 сая төгрөгийн биелэлт 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар хангагдаагүй байна.

Албан шаалдлагын хэрэгжилтийг тулган батлагаажуулахад 258.8 сая төгрөгийн 320 заалт албан шаардлагын 6 хувь буюу 15.7 сая

төгрөгийн 31 заалт албан шаардлагын хэрэгжилт тооцсон баримт материал ирүүлсэн бусад 94 хувь буюу 243.1 сая төгрөгийн 289 заалт албан шаардлагын биелэлт нотлох баримтаар дэмжигдэхгүй байна. Үүнээс 88.5 сая төгрөгийн 203 заалттай албан шаардлагыг хэрэгжүүлсэн талаар шалгагдагч байгууллагаас зөвхөн албан тоот ирсэн байхад хэрэгжилт тооцсон байлаа.

Санхүүгийн хяналт, шалгалтын тайлангаар дээрх хугацаанд 291 заалт зөвлөмж өгч ажилласан ба зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан эсэх, зөвлөмжийн мөрөөр шалгагдагч байгууллага ямар нэгэн ажил зохион байгуулсан эсэхийг эргэж тооцсон баримт материал байсангүй.

Өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг тулган баталгаажуулахдаа дотоод аудиторудтай ярилцлага хийж, нээлттэйгээр баримт материал хүлээн авсан ба аудитын хугацаанд 6.3 сая төгрөгийн актын биелэлтийн баримт материалыг шалгагдагч байгууллагаас нэмэлтээр авч тооцсон болно.

Аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь 2019-2020 онд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн үлэгдэлтэй газруудад хариуцлага тооцуулах саналыг төсвийн ерөнхийлөн захирагчид 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр 89 тоот албан бичгээр хүргүүлсэн ба үүнээс хойш дахин хандаагүй байлаа.

Дүгнэлт: Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх шалгагдагч байгууллагын нотлох баримт дотоод аудитын нэгжид хангалттай хэмжээнд байхгүй байна.

²⁵ Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ.

Дотоод аудитын үйл ажиллагаа нь төрийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад хувь нэмэр оруулж байна уу?

Санхүүгийн хяналт аудитын алба нь байгуулагдсан цагаасаа хойш Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан байдлаар ажиллаж санхүүгийн хяналт шалгалт хийж иржээ. Тус албаны байгуулагдсан хугацаанаас хойш хийсэн хяналт шалгалтын судалгааг гаргахад нийт 20 нэгж буюу 4 байгууллага (Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Ардын дуу бүжгийн алтай чуулга, Жаргалан сумын эрүүл мэндийн төв, Марал -Алтай ӨЭМТ) 2 сумын төсөвт байгууллага сангийн үйл ажиллагаанд 3-4 давтамжтай буюу жилд 1 удаа тогтмол шалгасан байна. Эдгээр байгууллагын шалгалтын дүнг нэгтгэхэд илэрсэн зөрчлийн дүн өссөн үзүүлэлттэй байна.

Дотоод аудитын дүрэмд зааснаар аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь Төрийн аудитын байгууллагатай жилийн ажлын төлөвлөгөө тайланг харилцан мэдээлэх, хамтарсан сургалт зохион байгуулах, арга зүй, туршлага харилцан солилцох, харилцан мэдээлэл солилцох хүрээнд хамтарч ажиллахаар заалттай боловч энэ хугацаанд хамтарч дээрх хэлбэрээр хамтарч ажиллаагүй байна.

Аудитын хугацаанд аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны үйл ажиллагаатай холбоотой санал асуулга авч тус байгууллагын үйл ажиллагааг шалгуулагчийн байр сууринаас хөндөхөд санал асуулгад оролцогчдын санал доорх байдалтай байна.

Санал асуулгад оролцогчдын 80.5 хувь аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны шалгалтад хамрагдсан бол үүний 48.8 хувь нь тус албаны хяналт шалгалт тухайн байгууллагад үр өгөөж бий болгосон гэж үзсэн байна.


Танай байгууллагын үйл ажиллагаанд доорх нэр бүхий байгууллагаас аль байгууллага нь хяналт шалгалт хийдэг вэ?




Аль байгууллагын хяналт шалгалт танд үр өгөөж бий болгосон үр дүнтэй хяналт шалгалт байсан вэ?



Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас танай байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх сургалт семинар зохион байгуулдаг уу?



Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас танай танай байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зөвлөн туслах зорилготой зөвлөгөө өгдөг үү?



Санал асуулгын дүнгээс үзэхэд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь орон нутгийн байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх сургалт семинар зохион байгуулдаггүй боловч зөвлөн туслах зорилготой зөвлөгөө өгч ажилладаг нь харагдаж байна.

Төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх чиглэлд хийсэн ажлын талаар: Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 37 байгууллагын 67 албан тушаалтанд шүүхийн шийдвэрээр 382.0 сая төгрөгийн цалингийн нөхөн олговор олгосон байхад төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын нэгж буюу аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба төсвөөс гарсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар үр дүнд хүрсэн ажил хийгээгүй байна. (Хавсралт№3)

Манай байгууллагаас жил бүрийн орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар албан тушаалтныг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсөн, халсны улмаас төсвөөс олгосон төлбөрийг нөхөн төлүүлэх ажил зохион байгуулах заалттай албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлсний дагуу аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд заасан хохирлыг төлүүлэх үүргийн хүрээнд 2020 онд 11 нэхэмжлэлийг Говь-Алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан байна. Гаргасан нэхэмжлэлээс 9 нэхэмжлэлийг нэхэмжлэгч буцаан татсан, 1 нэхэмжлэлийг хаяг тодорхойгүй гэх шалтгаанаар шүүх хүлээн авахаас татгалзсан, 2 нэхэмжлэлийг шүүхээр хэлэлцүүлэн нэхэмжлэгч нэхэмжлэх эрхгүй гэх үндэслэлээр нэхэмжлэлийг шаардлагыг бүхэлд хэрэгсэхгүй болгосон²⁶. Уг шүүхийн шийдвэрт журмын дагуу гомдол гаргаж эцэслээгүй буюу үр дүнд хүрээгүй байна.

Дүгнэлт: Аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны үйл ажиллагаа шалгагдагч байгууллагын үйл ажиллагаанд үр нөлөө бий болгож байгаа эсэхийг тооцох хангалттай нотлох баримт байхгүй байна.

Илрүүлэлт

- Хэрэгжээгүй шийдвэрийн үлдэгдэлд хариуцлага тооцох санал гаргаагүй байна.
- Шийдвэрийн хэрэгжилт тооцохдоо нотлох баримтад үндэслээгүй байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 37 байгууллага 66 албан тушаалтанд 370.2 сая төгрөгийн цалингийн нөхөн олговор олгосон байхад төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын нэгж буюу аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба төсвөөс гарсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар үр дүнтэй ажил хийгээгүй

²⁶ Говь-Алтай аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр 2020.03.02-ны өдрийн №133/ШШ2020/00180.

Говь-Алтай аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр 2020.03.02-ны өдрийн №133/ШШ2020/00181.

**ДҮГНЭЛТ: ДОТООД АУДИТААС ГАРГАСАН ШИЙДВЭРҮҮДИЙН ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ
НОТЛОХ БАРИМТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

**ДҮГНЭЛТ: АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ДЭРГЭДЭХ ДОТООД
АУДИТЫН НЭГЖ БУЮУ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБА НЬ БАЙГУУЛАГДСАН
ЦАГААСАА ХОЙШ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН БОЛОВЧ САНГИЙН
ЯАМНААС ГАРГАСАН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН СТАНДАРТЫГ ҮЙЛ
АЖИЛЛАГААНДАА МӨРДӨӨГҮЙ, УЛСЫН САЛБАРЫН ДОТООД АУДИТЫН
АРГАЧЛАЛЫГ БАРИМТАЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.**

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын нэгж нь үндсэн зорилго, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хяналт шалгалтын бусад байгууллагатай үр дүнтэй хамтран ажиллах

АЛБАН ШААРДЛАГА:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах албан шаардлага өгч байна. Үүнд:

АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИД

АЛБАН ШААРДЛАГА

- ✓ Албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга Д.Ганзоригт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж биелэлтийг 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт²⁷ ирүүлэх

АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ ДАРГАД

АЛБАН ШААРДЛАГА

- ✓ Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж буюу Санхүүгийн хяналт, аудитын албаны үйл ажиллагаанд батлагдсан стандарт, аргачлалыг мөрдүүлэх үр дүнтэй ажил зохион байгуулж биелэлтийг 2022 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт²⁸ ирүүлэх. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах

²⁷ Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Баянхайрхан баг Утас 70484030

²⁸ Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Баянхайрхан баг Утас 70484030

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ХАРИУ

№	Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны санал, тайлбар	Төрийн аудитын газрын аудитын II багийн хариу тайлбар
1	<p>Албан ажлаар сумд ажиллахад аймгийн Засаг даргын тамгын газраас тухай бүр нь автомашинаар бүрэн хангаж ажиллахгүй байгаа болно. Холбогдох хууль стандартад зааснаар хяналт, шалгалтын байгууллага хараат бусаар ажиллах шаардлагатай байдаг. Иймээс манай байгууллагад автомашин зайлшгүй хэрэгцээтэй.</p>	<p>Энэ асуудалд Засгийн газрын 2015 оны 483 дугаартай тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 6.1.4-т “Шаардлагатай бол тухайн байгууллагын байр, тоног төхөөрөмж, хэрэгслийг ашиглах”, аймгийн Засаг даргын 2014 оны А/545 дугаартай захирамжаар батлагдсан “Санхүүгийн хяналт шалгалтын болон дотоод аудитын дүрэм”-ийн 5.1.4-т “Санхүүгийн хяналт шалгалтын болон аудитын үйл ажиллагаанд шаардлагатай байр, тоног төхөөрөмж, хэрэгслийг үнэ төлбөргүй ашиглах” гэсэн заалтуудаар зохицуулагдаж байгаа билээ.</p> <p>Танай албанд автомашин байхгүй байгаа нь хараат бус байдалд нөлөөлж байна гэж үзэхгүй байна. Төсвийн ерөнхийлөн захирагч буюу аймгийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын нэгжийн тухайд автомашин шаардлагатай хугацааг гарган албаны шугамаар хандан шийдвэрлэх боломжтой дотоод нэгжүүдийн ойлголцлын асуудал байна.</p>
2	<p>Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний асуудалд одоогийн бүтэц, төсвөөр чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй юм. Тус алба нь боловсон хүчний нөөц буюу батлагдсан орон тооноос хамаарч дотоод аудит хийх чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байгаа ба Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны байгууллагуудад 3-4 жилд нэг удаа санхүүгийн хяналт шалгалтыг хийж байна.</p>	<p>Төрийн албан хаагч нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т “Албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах” үүрэгтэй.</p> <p>Албаны даргын батлагдан мөрдөж байгаа ажлын байрны тодорхойлолтод зааснаар доорх зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангахаар байна.</p> <p>Албан тушаалын зорилго: “Төрийн, орон нутгийн өмчийн байгууллагуудад Төсөв, санхүүгийн болон бусад хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аймгийн Засаг даргыг бодлогын зөвлөгөө, мэдээллээр хангаж, мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлэх, агентлагийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг аймгийн Засаг даргын өмнө хариуцан тайлагнана.”</p> <p>Албан тушаалын зорилт: Төрийн байгууллагуудад хийх дотоод аудит ба салбарын хяналт шалгалтын бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэх, Дотоод аудитын чиглэлээр эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах бүрэн эрхийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийж илэрсэн нөхцөлийг арилгах талаар санал дүгнэлт боловсруулах хэрэгжилтэд хяналт тавих, Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм журам стандартыг хэрэгжүүлэх зорилтыг хангах албан тушаалын гүйцэтгэх чиг үүргүүд болно.</p> <p>Батлагдсан бүтэц төсөвт багтаан дээрх чиг үүргийн хэрэгжилтийг хангах нь албаны даргын үүрэг юм.</p>

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО, ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

№	Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны санал, тайлбар	Төрийн аудитын газрын аудитын II багийн хариу тайлбар
3	<p>Санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөөний төслийг Төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулан, саналыг нь тусгаж, батлуулан ажилладаг. Хяналт шалгалтын удирдамжийг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд 10.12(Улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, энэ хуулийн 10.9-д заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. 10.12.5(төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжийг батлах))-д заасны дагуу улсын ахлах байцаагч буюу албаны дарга баталдаг. Төсвийн ерөнхийлөн захирагч ажлын ачаалал ихтэй байдаг тул зөрчил ихтэй нэн даруй анхаарах хяналт шалгалтын дүн болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн улирал тутмын хяналтыг танилцуулж ажилладаг. Жилийн эцсийн гүйцэтгэлээр хяналт шалгалтад хамрагдсан байгууллага бүрийн зөрчлийн үзүүлэлтээр гаргасан тоон болон бичмэл тайланг Төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнадаг.</p>	<p>Таны тайлбарт бичсэн Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн заалт нь “Мэргэжлийн хяналтын улсын байцаагч, түүний нийтлэг бүрэн эрх”-д хамаарах заалт юм. Танай алба нь төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын нэгж бөгөөд дотоод аудитор буюу санхүүгийн хяналт шалгалтын улсын(ахлах) байцаагчид ажилладаг билээ. Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчид нь Дотоод аудитын дүрэм, Санхүүгийн хяналт шалгалтын стандартад заасан эрх үүрэгтэй. Мөрдөж байгаа дүрэм стандартын зөрүүтэй байдал тайлангийн нэг дэх хэсэгт тусгагдсан. Албаны үйл ажиллагаа төсвийн ерөнхийлөн захирагчийн ажлын ачаалалтай байдлаас үл хамааран албан журмаар явагдана. Аудитад танай албаны анх үүсгэн байгуулагдсанаас хойшхи бүх баримт материал хамрагдсан ба төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнасан, танилцуулсан албан ёсны баримт байгаагүй болно.</p>
4	<p>Санхүүгийн хяналт шалгалтын стандартыг бүрэн биш боловч тодорхой хэмжээнд мөрдөн ажилладаг. Үнэ цэнгүй гэсэн ойлголтыг ямар нотлох баримтыг үндэслэн аудитын тайланд тусгасан тухайгаа тайлбарлана уу?</p>	<p>Төрийн аудит MNS 6817-5:2020 7.5.1-т “Тайлангийн агуулга аудитор дэлгэрэнгүй үнэмшилтэй, цагаа олсон, уншихад ойлгомжтой, тэнцвэртэй аудитын тайлан бэлтгэхийг хичиээх ёстой... бүх маргаантай асуудлыг хөндөх ёстой... тайланг агуулгын хувьд хүлээн зөвшөөрсөн, нарийн тодорхой бөгөөд хоёрдмол утгагүй хэлээр томёолох ёстой... Төрийн аудит MNS 6817-7: 2020 7.4.1-т “Аудитор нь аудитын тайланг иж бүрэн, үнэмшилтэй, цагаа олсон, уншихад ойлгомжтой, тэнцвэртэй байдлаар бэлтгэх ёстой.”...</p> <p>Тухайлбал: Танай байгууллага 2020 оны 08 дугаар сараас хойш өөрийн албаны вэб хуудастаа мэдээлэл тавиагүй байдал, төсвийн ерөнхийлөн захирагчид 2020 оны 11 дүгээр сард хариуцлага тооцох саналыг албан тоотоор хүргүүлсэн боловч энэ талаар төсвийн ерөнхийлөн захирагчаас ямар нэгэн арга хэмжээ аваагүй байгаа байдал, төсвийн ерөнхийлөн захирагчид албаны үйл ажиллагаагаа тайлагнадаггүй байдал, хийсэн хяналт шалгалтын үр дүнг тодотгох шалгалтын мөрөөр ямар нэгэн ажил зохион байгуулаагүй байдал, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил арилсан эсэхэд нотлох баримтаар дэмжигдсэн нотлох зүйл цуглуулдаггүй байдлыг аудиторын зүгээс хараат бусаар дүгнэхэд танай албаны үйл ажиллагаа үнэ цэнийг бий болгохгүй байна гэх үг хэллэг хэрэглэх үндэслэл болсон болно.</p> <p>Монгол хэлний үгийн тайлбарт үнэ цэн гэдэг үг нь “юмны чухаг хэрэгцээтэй чанар” гэж тодорхойлогдсон байдаг. Үгийн сонголтыг өөрчилсөн болно.</p>

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО, ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

№	Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны санал, тайлбар	Төрийн аудитын газрын аудитын II багийн хариу тайлбар
5	<p>Санал асуулгад аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанаас танай байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах зорилготой зөвлөгөө өгдөг үү? гэсэн асуултад 68.3 хувь тийм гэж хариулсан байна. Уг хариулт нь дүгнэлтэд (Санал асуулгын дүнгээс үзэхэд Санхүүгийн хяналт аудитын албаны үйл ажиллагаа шалгагдагч байгууллагын үйл ажиллагаанд үр нөлөө бий болгохгүй байна) бичсэнтэй нийцэхгүй байна. Санал асуулгад оролцсон байгууллагуудын 68.3 хувь нь тийм гэж хариулсан байгаа нь эдгээр байгууллагууд шалгалтад хамрагдсанаар зөвлөгөө тусалцаа авч, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлснийг илтгэж байна. Төрийн аудитын байгууллагаас өөрийн байгууллагыг оролцуулсан санал асуулгын хуудсаар шалгагдагч байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудаас эрэмбэ тогтоох асуулга авч тус байгууллагын үйл ажиллагааг дүгнэсэн байгаа нь хараат бус хяналтын тогтолцоонд нийцэхгүй, санал асуулга үнэн зөв гэж үзэхэд эргэлзээтэй байна.</p>	<p>Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан дэлхий нийтээрээ цахим орчинг ашиглаж байгаа энэ үед шинэ шинэлэг зүйлсд нээлттэй эерэг хандлагатай байж цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхах нь хэн бүхэнд тулгарч байгаа асуудал билээ.</p> <p>Санал асуулга авахдаа ямар нэгэн эрэмбэ тогтоох хүсэл сонирхол агуулаагүй бөгөөд google account ашиглан авсан тул үнэн зөв байдал нь баталгаатай юм.</p> <p>Гэвч танд эргэлзээ төрүүлсэн нөхцөл байдлыг харгалзан үзэж тайланд холбогдох засварыг хийлээ.</p> <p>Харин зөвхөн санал асуулгын дүнгээс дүгнэлт өгөөгүй тул тайланд энэ байдлыг дэлгэрүүлсэн болно.</p>
6	<p>Гүйцэтгэлийн аудитын сэдэв “Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт” гэсэн нь аудитын тайланд зөвхөн Санхүүгийн хяналт, аудитын албаны үйл ажиллагааны талаар тусгасан байгаатай уялдахгүй байна.</p>	<p>Төрийн аудит MNS6817-1:2020 5.3.2.2-т “ Гүйцэтгэлийн аудитын шалгах зүйлийг аудитын зорилго тодорхойлно. Шалгах зүйлд тухайлсан хөтөлбөр, байгууллага, хөрөнгө, тодорхой үйл ажиллагаа (уг үйл ажиллагааны үр дүн, бүтээмж, үр нөлөө), эсхүл үүссэн нөхцөл байдал (түүний шалтгаан үр дагавар) болон эдгээр зүйлсийн алиных нь ч талаарх санхүүгийн ба санхүүгийн бус мэдээлэл багтаж болно. Аудитор тогтоосон шалгуур хангасан эсэхийг үнэлэхийн тулд шалгах зүйлийг хэмжиж үнэлнэ” гэж заагдсан байдаг.</p> <p>Энэ аудит Монгол улсын хэмжээнд нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөр нэгдсэн арга зүйгээр хийгдэж байгаа аудит бөгөөд аудитын төлөвлөлт, гүйцэтгэлийн талбарын ажил хийгдэх үед зохих баримт, судалгаа тооцоог гаргаж зохих төвшинд үнэлсэн билээ.</p> <p>Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын дагуу үе шатны ажлын баримт материал судалгаа тооцоо бүрийг харгалзан нэгтгэсэн тайлан нь батлагдсан асуудлын шинжилгээнд дурдсан асуултад хариулт өгөх байдлаар бичигдсэн болно.</p>

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО, ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

№	Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны санал, тайлбар	Төрийн аудитын газрын аудитын II багийн хариу тайлбар
7	Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалтай холбоотойгоор заавар зөвлөмжийг шалгалтын танилцуулгаар өгч ажилладаг. Бие даасан зөвлөн туслах үйл ажиллагаа, явуулаагүй бөгөөд хэвлэмэл хуудсаар зөвлөмж хүргүүлж ажиллаагүй болно.	Санхүүгийн хяналт шалгалтын стандарт 3.5 Шалгалтын мөрөөр ажиллах хэсэг "Шалгалтын үр дүнд илэрсэн дутагдлыг арилгах болон зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар улсын байцаагч анхаарч ажиллах ёстой", 09-т "Хяналт шалгалтын байгууллагын дарга шалгалтын мөрөөр ажиллахдаа анхаарах зүйлс: Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний хугацаа, авагдсан арга хэмжээг судалж, үнэлж дүгнэх, шаардлагатай тохиолдолд авсан арга хэмжээг баталгаажуулах, хэрэв шаардлагатай бол дахин шалгалт оруулах, албан шаардлага бичих" гэсэн заалттай. Заалтын дагуу хийсэн ажлыг үнэлэхэд ямар нэгэн баримт байгаагүй учир тайланд бичигдсэн.
8	Албаны бүтэц орон тоо баталсан шийдвэрт өөрчлөлт ороогүй байхад 2020 оны 12 дугаар сараас албаны дарга 1, дотоод аудитор 5 гэсэн бүтцээр ажилласан. Нягтлан бодогч архив бичиг хэргийн ажилтны орон тоонд ажилладаг байсан албан хаагчийг ТЕЗ-ийн шийдвэргүйгээр албаны дарга шууд дотоод аудитораар томилон ажиллуулж 2.6 сая төгрөгийн цалин илүү олгосон гэх зөрчилд төлбөрийн акт тогтоохоор төсөл ирүүлсэн байна. Дээрх асуудалд дараах тайлбарыг хүргүүлж хүлээн зөвшөөрөхгүй байна. ... төсвийн шууд захирагчийн бүрэн эрхийн асуудал гэж үзэж байна... зөрчсөн шийдвэр гэж үзэж байна.	Аудитын гүйцэтгэх үе шатны үед илэрсэн зөрчлийг албаны дарга, болон зөрчил заасан албан тушаалтанд аль алинд танилцуулж баримтжуулсан. Санал тайлбарт хавсаргасан баримт материал хангалттай зохистой найдвартай байх тул шийдвэрийн төслийг хаслаа.
9	ГАА дахь Сумын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр буруутай шийдвэр гаргасны улмаас төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг СХА-нд чиг үүргийн хүрээнд харьяалагдахгүй гэж үзсэн тул манай байгууллагад хамаарахгүй болно. Холбогдох шүүхийн шийдвэрийг хавсаргав.	Манай байгууллагаас жил бүрийн орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар албан тушаалтныг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсөн, халсны улмаас төсвөөс олгосон төлбөрийг нөхөн төлүүлэх ажил зохион байгуулах заалттай албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлсний дагуу аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд заасан хохирлыг төлүүлэх үүргийн хүрээнд 2020 онд 11 нэхэмжлэлийг Говь-Алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан байна. Гаргасан нэхэмжлэлээс 9 нэхэмжлэлийг нэхэмжлэгч буцаан татсан, 1 нэхэмжлэлийг хаяг тодорхойгүй гэх шалтгаанаар шүүх хүлээн авахаас татгалзсан, 2 нэхэмжлэлийг шүүхээр хэлэлцүүлэн нэхэмжлэгч нэхэмжлэх эрхгүй гэх үндэслэлээр нэхэмжлэлийг шаардлагыг бүхэлд хэрэгсэхгүй болгосон ¹ . Уг шүүхийн шийдвэрт журмын дагуу гомдол гаргаж эцэслээгүй буюу үр дүнд хүрээгүй байна. Иймд зөрчлийн заалтад албан шаардлага нэмлээ.

¹ Говь-Алтай аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр 2020.03.02-ны өдрийн №133/ШШ2020/00180.
Говь-Алтай аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр 2020.03.02-ны өдрийн №133/ШШ2020/00181.

Баруун аймгуудын дотоод аудитын нэгжийн батлагдсан
төсөв түүний гүйцэтгэл

(сая төгрөг)

№	Аймгийн нэр	Нийт төсөв					
		2019		2020		2021	
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл /2021.09.30-рх/
1	Говь-Алтай	119.16	118.57	123.80	122.90	126.80	89.90
2	Завхан	163.30	163.60	188.40	186.80	179.80	128.00
3	Увс	115.09	115.09	169.01	163.85	164.04	135.52
4	Ховд	128.61	128.61	145.29	145.29	213.57	149.62
5	Баян-Өлгий	150.97	150.97	119.43	113.40	125.01	86.60
		677.13	676.84	745.92	732.23	809.22	589.64

Баруун аймгуудын дотоод аудитын нэгжийн цалингийн
сангийн гүйцэтгэл

(сая төгрөг)

№	Аймгийн нэр	Цалингийн сан					
		2019		2020		2021	
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл /2021.09.30-рх/
1	Говь-Алтай	87.5	87.4	100.1	100.1	100.1	74.4
2	Завхан	135.1	135.1	163.6	163.3	91.7	64.5
3	Увс	86.33	85.77	113.55	114.11	112.81	78.15
4	Ховд	83.46	83.44	94.20	94.20	122.17	85.75
5	Баян-Өлгий	93.58	93.58	93.67	93.58	97.10	75.82
		485.96	485.29	565.12	565.30	523.88	378.63

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО, ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

Хавсралт №3

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын олгосон
цалингийн нөхөн олговрын судалгаа сая.төг

№	Байгууллагын нэр	Ажлаас үндэслэлгүй халагдсан этгээд	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	нийт олгосон нөхөн олговор
1	Чандмань сумын Сургууль	Ц.Жүгдэрнамжил	3.69	-	1.78	-	-	5.47
2	Есөнбулаг сумын ЗДТГ	Ж.Ганбат	1.55	6.54	6.76	-	-	14.86
		М.Дугармаа	-	2.84	0.44	-	-	3.28
		З.Болорнаран	-	2.84	0.22	-	-	3.06
		Д.Баярмаа	-	2.50	0.19	-	-	2.69
3	Есөнбулаг сумын ИТХ	С.Билэгбаатар	6.38	-	3.08	-	-	9.46
4	Алтай хотын Тохижилт үйлчилгээний газар	Х. Одгэрэл	5.82	-	10.74	-	-	16.56
		Л. Нармандах	1.03	-	-	0.49	-	1.52
		М.Эрдэнэчимэг	-	-	1.62	-	-	1.62
5	Есөнбулаг сумын 5 дугаар цэцэрлэг	Л.Туяа	2.65	-	-	-	-	2.65
6	Есөнбулаг сумын 2 дугаар цэцэрлэг	Н.Гантулга	2.09	-	-	-	-	2.09
		Д.Ганчимэг	2.74	-	1.69	-	-	4.43
7	Есөнбулаг сумын 2 дугаар сургууль	М.Отгонжаргал	-	-	3.83	-	-	3.83
8	Есөнбулаг сумын 3 дугаар сургууль	н.Буян-Ундрах	1.75	-	-	-	-	1.75
		М.Нохойхүү	-	-	-	-	13.58	13.58
		Ж.Энхбаатар	-	-	-	-	5.53	5.53
		Д.Эрдэнэчимэг	-	-	-	-	3.57	3.57
9	Есөнбулаг сумын 4 дүгээр сургууль	Т.Ганцэцэг	-	-	-	-	0.24	0.24
10	Баян-Уул сумын ЗДТГ	Д.Баянбаатар	1.99	-	-	-	-	1.99
		Д.Хасбаатар	-	-	-	1.26	-	1.26
11	Дэлгэр сумын ЗДТГ	А.Жигжидбавуу	18.20	-	-	4.22	-	22.42
		М.Машбат	-	1.23	0.25	-	-	1.48
12	Дэлгэр сумын ЭМТ	Ц.Долсүрэн	3.67	-	2.93	3.48	-	10.08
13	Дэлгэр сумын ИТХ	Б.Гүнмэргэн	8.44	1.13	-	-	-	9.57
14	Дэлгэр сумын Цэцэрлэг	Н.Хандармаа	4.04	-	-	-	-	4.04
		С.Ундармаа	6.11	-	-	-	-	6.11
		Ц.Одончимэг	0.69	-	-	-	-	0.69
		Г.Оюут	1.30	-	-	-	-	1.30
15	Жаргалан сумын Сургууль	Ш. Болдбат	2.00	-	-	-	-	2.00
16	Тайшир суын Сургууль	Д.Цэвгээ	7.09	-	-	-	-	7.09
17	Тонхил сумын ЗДТГ	Ж.Ганзориг	3.01	-	-	-	-	3.01

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО, ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

18	Халиун сумын ЗДТГ	Ш.Оюунчимэг	3.33	-	9.56	-	-	12.89
19	Хөхморьт сумын ЗДТГ	З.Нүрээд	7.98	-	-	0.91	-	8.90
		Ш.Онолбаатар	6.84	-	-	-	-	6.84
20	Шарга сумын ЗДТГ	Наранцэцэг	1.82	-	-	-	-	1.82
21	Шарга сумын Сургууль	Л.Ганболд	1.70	-	-	-	-	1.70
22	Шарга сумын Цэцэрлэг	Н.Ариунбаяр	1.25	-	-	-	-	1.25
23	Эрдэнэ сумын ЗДТГ	Б.Буянзаяа	3.01	0.54	-	-	-	3.54
24	Аймгийн ИТХ	Г.Соёлоо	0.90	-	4.67	-	-	5.57
		Б.Наваан-Юндэн	8.26	0.82	-	-	-	9.08
		Л.Болормаа	-	-	24.95	-	-	24.95
25	Сум дундын Ойн анги	Д.Алтанхүү	-	-	-	-	2.27	2.27
26	ГХБХБГ	Ч.Батсуурь	0.86	-	-	-	-	0.86
		М.Ууган-Эрдэнэ	-	-	-	-	8.48	8.48
		М.Мөнхцэцэг	-	-	-	6.41	-	6.41
27	Нийтлэг-Үйлчилгээ"ОНТҮГ	Б.Төгсжаргал	3.27	-	-	-	-	3.27
		Ж.Дорж-Арилдий	-	-	-	1.95	-	1.95
		Т.Чинбат	-	-	-	0.52	0.43	0.95
28	Бигэр сумын Эрүүл мэндийн төв	Р.Сарантуяа	-	5.28	10.84	-	-	16.12
29	Ардын дуу бжгийн Алтай чуулга	Э.Отгонбаатар	-	-	15.10	0.20	-	15.30
		О.Отгонсүрэн	-	-	-	-	7.79	7.79
		Х.Цэендолгор	-	-	-	-	1.66	1.66
		Батдэлгэр	-	-	-	1.19	-	1.19
		А.Төмөрбаатар	-	-	-	-	10.94	10.94
		У.Сайнжаргал	-	-	-	-	4.24	4.24
		М.Нандинцэцэг	-	-	-	2.47	-	2.47
30	Орон нутгийн өмчийн газар	Ц.Цэзмаа	-	-	6.84	-	-	6.84
31	Баянтоорой тосгоны Сургууль	Б.Батзориг	-	-	-	-	8.60	8.60
		Б.Бүндэн	-	-	5.07	-	-	5.07
32	Бугат сумын Тахийн тал бага сургууль	Л.Бэлэгдэмбэрэл	-	-	3.51	-	-	3.51
33	Нийтийн номын сан	Д.Одсурмаа	-	-	0.08	1.00	-	1.08
34	Аймгийн ЗДТГ	В.Рэнцэндорж	-	-	-	2.00	2.00	4.00
		Ч.Бат-Эрдэнэ	-	-	-	-	14.20	14.20
		Р.Төмөрчөдөр	-	-	-	-	3.13	3.13
35	Тонхил сумын Сургууль	Д.Ганчулуун	-	-	-	4.48	-	4.48
36	Хөхморьт сургууль	Г.Балгармаа	-	-	-	2.89	-	2.89
37	Биеийн тамир спортын газар	Х.Батболд	-	-	-	0.22	0.40	0.62
Дүн			123.47	23.72	114.13	33.69	87.08	382.09




Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт


Аудитын нэр: "Төрийн байгууллагын дотоод аудитын тогтолцоо чиг үүргийн хэрэгжилт" гүйцэтгэлийн аудит

Аудитын код: ГАА-2021/15-ШТА-ГА

Байгууллагын нэр: Говь-Алтай аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба

№	Аудитын чиглэл/асуулт	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (сая.төг)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал тайлбар	Гаргасан шийдэл
А	1	2	3	4	5	6
1	Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт	Аймгийн санхүүгийн хяналт, аудитын алба нь үйл ажиллагаандаа Сангийн яамнаас баталсан "Санхүүгийн хяналт шалгалтын стандарт", "Улсын салбарын дотоод аудитын аргачлал"-ыг мөрдөж ажиллаагүй		Албан шаардлага өгөх Сахилгын шийтгэл оногдуулах	Санал тайлбар гаргаагүй	Албан шаардлага өгөх Сахилгын шийтгэл оногдуулах
2	Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт	Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь хяналт шалгалтын бусад байгууллагатай уялдаа холбоотой ажилладаггүй		Албан шаардлага өгөх	Санал тайлбар гаргаагүй	Зөвлөмж өгөх
3	Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт	Батлагдсан бүтэц орон тоог баримталж ажиллаагүйгээс 2.6 сая төгрөгийн цалин илүү олгосон	2.6	Төлбөрийн акт өгөх	Санал гаргасан	Хүлээн авсан
4	Хуулийн хэрэгжилттэй холбоотой	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 37 байгууллага 67 албан тушаалтанд 2017-2020 онд 382.0 сая төгрөгийн цалингийн нөхөн олговор олгосон байхад аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба хохирлыг нөхөн төлүүлэх талаар үр дүнтэй ажил хийгээгүй.		Албан шаардлага өгөх	Санал гаргасан (Судалгаа)	Албан шаардлага өгөх

Бэлтгэсэн: Ахлах аудитор:  Б.Цэцэгмаа
 Анхан шатанд хянасан:  Д.Эрдэнэчимэг
 Аудитын менежер:  Х.Түвшинбаяр
 Хоёр дахь шатанд хянасан:
 Дарга, Тэргүүлэх аудитор:

Танилцаж зөвшөөрсөн:
 Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга:

 Д.Ганзориг

